

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2011 ОНЫ 4 ДҮГЭЭР
УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2011.12.31

Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦИЙН ТАЛААР:

Манай улсын хэмжээнд 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 195 ББСБ байгаагийн 92 нь буюу 47.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 92 ББСБ-ын 39 нь буюу 42.4% нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, 53 нь буюу 57.6% нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 92 ББСБ-ын 66 нь ирүүлж, 26 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 71.7 хувь байна.

/Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, танилцуулгад хавсаргав/.

Мэдээ ирүүлээгүй 26 ББСБ-ын 18 нь тус хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй бөгөөд цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг ирүүлсэн, 8 нь гадаад валютын арилжааны мэдээ болон ямар нэгэн тайлбар бичиг ирүүлээгүй болно.

Тус Хорооноос тайлант 4 дүгээр улиралд нийт 3 ББСБ-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос “Хутагт гэрэгэ ББСБ” ХХК, “Эс Эс Эн Жи ББСБ” ХХК-д зөвхөн гадаад валютын арилжааны, “Газар капитал ББСБ” ХХК-д зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээний хамт эрхлэхийг тус тус зөвшөөрчээ.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 7 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс 3 нь хүчингүй болж, 4 нь сэргээгдсэн бөгөөд үүний 3 нь буюу “Ворлд проспер ББСБ” ХХК, “Мөнгөн хөврөлт ББСБ” ХХК, “ӨБЦ ББСБ” ХХК зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ба дүрмийн сангийн хэмжээгээ Хорооноос тогтоосон 100,000,000.00 /нэг зуун сая/ төгрөгт хүргэсэн, 1 нь буюу “Жи си ай пи ББСБ” ХХК-ийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь сэргээгдсэн байна.

Мөн 2 ББСБ буюу “Каражат ББСБ” ХХК, “Жи си ай пи ББСБ” ХХК-ийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгожээ.

Гадаад валютын арилжааны 2011 оны 4 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

Мэдээ ирүүлсэн нийт 66 ББСБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭ ИРҮҮЛСЭН ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭНИЙ ИРЦ	ӨСӨЛТ, БУУРАЛТ ХУВИАР <i>/өмнөх улирлаас /</i>
1	2010 оны 1 дүгээр улирал	112	31	40.4%	0.0%
2	2010 оны 2 дугаар улирал	110	43	39.0%	-1.4%
3	2010 оны 3 дугаар улирал	109	48	44.0%	5.0%
4	2010 оны 4 дүгээр улирал	95	71	74.7%	30.7%
5	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	3.8%
6	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
7	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
8	2011 оны 4 дүгээр улирал	92	66	71.7%	17.5%

Дээрх хүснэгтээс үзэхэд мэдээ ирүүлсэн ББСБ-уудын тоо 2010 оны 4, 2011 оны 2 дугаар улирлынхаас 8-аас 11-ээр буурсан бөгөөд мэдээний ирц 2010 оны 1,2,3 дугаар улиралд 40.4% - 44.0% байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 74.7%, 2011 оны 1 дүгээр улиралд 78.5% болж өмнөх улирлуудаас 30.7% - 38.1%-иар өссөн харин 2011 оны 2 дугаар улирлын байдлаар 61.2% болж өмнөх улирлаас 17.3%-иар, 3 дугаар улирлын байдлаар 54.2% болж өмнөх улирлаас 7.0%-иар буурсан, 2011 оны 4 дүгээр улиралд 71.7% болж өмнөх улирлаас 17.5%-иар өсч, 2010 оны жилийн эцсийнхээс 3.0%-иар буурсан үзүүлэлттэй гарч байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо улирлаас улиралд буурч байгаа хэдий ч мэдээний ирц нэмэгдэх хандлагтай байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ТАЛААР:

Энэхүү нэгтгэлийг ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн хийхдээ тэдгээрийн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютын болон худалдсан гадаад валют бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцсон болно.

Худалдан авсан болон худалдсан гадаад валютуудыг төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тооцож, өмнөх улиралтай харьцуулж үзвэл дараах байдлатай байна.

1. Худалдаж авсан нийт гадаад валют:

<i>/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/</i>						
д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;/-/ <i>/өмнөх улирлаас/</i>	2011 ОНЫ IV улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;/-/ <i>/өмнөх улирлаас/</i>

Гадаад валютын арилжааны 2011 оны 4 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

1	ТӨГРӨГ	168,060,826.6	196,156,917.3	28,096,090.7	149,731,203.9	-46,425,713.4
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	132,278.3	160,975.7	28,697.4	120,707.4	-40,268.3
3	ДУНДАЖ ХАНШ	1,270.51	1,218.55	-51.96	1,240.45	21.9

Дээрх хүснэгтээс үзэхэд тайлант хугацаанд худалдаж авсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг 2011 оны 2 дугаар улирлынхтай харьцуулахад 46,425,713.4 мянган төгрөг буюу 23.7 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлынхтай харьцуулахад 18,329,622.7 мянган төгрөг буюу 10.9 хувиар мөн ам.долларт хөрвүүлсэн дүнг 2011 оны 2 дугаар улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 40,268.3 мянган ам.доллар буюу 25.0 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлынхтай харьцуулахад 11,570.9 мянган ам.доллар буюу 8.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарч байна.

Гадаад валют бүрийг худалдаж авсан нийт валютын ханшийг ам.долларт хөрвүүлж, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,240.45 төгрөг болж байна. Энэ нь:

- 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд /1,240.45₮:1,270.51₮/ 30.06 ам.доллар буюу 2.3 хувиар буурсан;

- 2011 оны 2 дугаар улирлын дүнтэй харьцуулж үзэхэд /1,218.55₮:1,240.45₮/ 21.9 ам.доллар буюу 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Худалдсан нийт гадаад валют:

/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ II улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/	2011 ОНЫ IV улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/
1	ТӨГРӨГ	163,800,118.1	237,093,710.9	73,293,592.8	157,659,283.2	79,434,427.7
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	128,875.0	194,131.0	65,256.0	126,481.5	-67,649.5
3	ДУНДАЖ ХАНШ	1,271.0	1,221.31	-49.69	1,246.50	25.19

Дээрх хүснэгтээс үзэхэд худалдсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх улирал буюу 2011 оны 2 дугаар улирлын дүнтэй харьцуулж үзэхэд 79,434,427.7 мянган төгрөг буюу 33.5 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлынхтай харьцуулахад 6,140,834.9 мянган төгрөг буюу 3.7 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнг 2011 оны 2 дугаар улирлын дүнтэй харьцуулахад 67,649.5 мянган ам.доллар буюу 34.8 хувиар, 2010 оны 4 дүгээр улирлынхтай харьцуулахад 2,393.5 мянган ам.доллар буюу 1.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валют бүрийг худалдсан нийт валютын ханшийг ам.долларт хөрвүүлж, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,246.50 төгрөг болж байна. Үүнийг:

Гадаад валютын арилжааны 2011 оны 4 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

- 2010 оны 4 дүгээр улирлын дүнтэй харьцуулж үзэхэд /1,246.50₮:1,271.00₮/ 24.5 ам.доллар буюу 1.9 хувиар буурсан;

- 2011 оны 2 дугаар улирлын дүнтэй харьцуулж үзэхэд /1,221.31₮:1,246.50₮/ 25.2 ам.доллар буюу 2.0 хувиар өссөн байна.

ББСБ-уудын ирүүлсэн мэдээгээр тэдгээрийн 2011 оны 3 дугаар улиралд худалдаж авсан нийт гадаад валютын мөнгөн дүнг худалдсан нийт гадаад валютын мөнгөн дүнтэй харьцуулж үзэхэд худалдсан гадаад валютын дүн худалдан авсан гадаад валютын нийт дүнгээс /157,659,283.2₮-149,731,203.9₮/ 7,928,079.3 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар, /126,481.5\$ - 120,707.4\$/ 5,774.1 ам.доллараар буюу 4.6 хувиар тус тус их гарч байна.

Тайлант хугацаанд худалдаж авсан болон худалдсан нийт гадаад валютуудын ханшийг ам.долларт шилжүүлж тэдгээрийн хоорондын зөрүүг авч үзвэл:

- Худалдан авсан нийт гадаад валютын ам.долларт хөрвүүлсэн дундаж ханш 1,240.45 төгрөг;

- Худалдсан нийт гадаад валютын ам.долларт хөрвүүлсэн дундаж ханш 1,246.50 төгрөг ба ханшийн зөрүү буюу худалдсан гадаад валютын ханшийн дүн худалдсан валютынхаас 6.05 төгрөгөөр илүү байна.

Энэхүү дүнд үндэслэн гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийн зөрүү боломжийн түвшинд байна гэж үзэж байна.

Ам.долларын албан болон зах зээлийн ханш тус тайлант хугацаанд буюу 7 дугаар сараас эхлэн бага багаар чангарсаар 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монголбанкнаас зарласан албан ханшаас ББСБ-уудын худалдаж авсан ханшийн дундаж дүн 2 төгрөг 50 мөнгөөр, худалдах ханшийн дундаж дүн 5 төгрөг 40 мөнгөөр тус тус их гарч байна.

Ам.долларын албан болон зах зээлийн ханшийг 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

д/ д	ҮЗҮҮЛЭЛТ	2011.7.31	2011.8.31-	2011.9.30-	Дундаж ханш	Дундаж ханш
		-ны өдөр	ний өдөр	ны өдөр	/1+2+3:3/	/2,3,4А:2,3,4Б/
		1	2	3	4	5
1	Монголбанкнаас зарласан ханш	1,251.25	1,248.67	1,285.64	1,261.85	-
2	Цэцэг төв:					
	А. Худалдан авах	1,250.00	1,251.00	1,288.89	1,263.30	1,264.49
	Б. Худалдах	1,252.00	1,253.00	1,292.00	1,265.67	
3	Найман шарга:					
	А. Худалдан авах	1,250.00	1,249.00	1,287.00	1,262.00	1,263.50
	Б. Худалдах	1,252.00	1,253.00	1,290.00	1,265.00	

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд:

Гадаад валютын арилжааны 2011 оны 4 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

1. Худалдаж авсан нийт валютын 9.7%-ийг хуулийн этгээдээс, 90.3%-ийг иргэдээс худалдан авч;
2. Худалдсан нийт валютын 14.5%-ийг хуулийн этгээдэд, 85.5%-ийг иргэдэд тус тус худалдсан байгаагаас үзэхэд ББСБ-ууд нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар ихэвчлэн иргэдэд үйлчилж ирснийг харуулж байна.

Тайлант 3 дугаар улиралд ББСБ-ууд нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар нийт 307,390,487.1 мянган төгрөгийн буюу 247,188.9 мянган ам.долларын гүйлгээ хийгдсэн байгаагийн 48.8 хувь нь гадаад валютыг худалдаж авсан гүйлгээ, 51.2% нь гадаад валютыг худалдсан гүйлгээ байна. Энэ нь:

- 2011 оны 2 дугаар улирлынхаас /433,250,628.2₮ - 307,390,487.1₮/ 125,860,141.1 мянган төгрөгөөр буюу 29.1 хувиар;

- 2010 оны 4 дүгээр улирлынхаас /331,860,944.7₮ - 307,390,487.1₮/ 24,470,457.6 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2011 оны 2 дугаар улиралд буюу 4,5,6 дугаар саруудад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад гадаадын хөрөнгө оруулалт нилээдгүй орж ирсэн төдийгүй ямааны ноолуур худалдан авахаар урд хөршөөс орох валютын хэмжээ өссөн. Ийнхүү гадаад валютын нийлүүлэлт нэмэгдсэнээр валютын ханш буурахад нөлөөлсөн.

Харин 3 дугаар улиралд улирлын шинж чанартай үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэнээс гадаад валютын эрэлт, хэрэгцээ өсч үүнийг даган валютын ханш нэмэгдсэн гэж үзэж байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2010 оны жилийн эцэс 2011 оны 2,3 дугаар улирлын байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ДУНДАЖ ДҮН		
			2010 оны IV улирал	2011 оны II улирал	2011 оны IV улирал
1	АНУ доллар	USD	1,271.00	1,219.93	1,248.43
2	Английн фунт	GBP	1,930.96	1,902.08	1,972.27
3	Евро	EUR	1,713.68	1,753.09	1,733.49
4	БНХАУ-ын юань	CNY	188.00	188.06	191.60
5	БНСУ-ын вон	KRW	1.04	1.23	1.11
6	ОХУ-ын рубль	RUB	41.20	42.87	41.60
7	Японы иен	JPY	15.50	15.04	15.79

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг авч үзүүлвэл дараах байдалтай байна. Үүнд:

/ТӨГРӨГӨӨР/

Гадаад валютын арилжааны 2011 оны 4 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ /ӨСӨЛТ +; БУУРАЛТ -/		
			2010 оны IV улирал	2011 оны II улирал	2011 оны IV улирал
1	АНУ доллар	USD	-	- 51.07	28.50
2	Английн фунт	GBP	-	- 28.88	70.19
3	Евро	EUR	-	39.41	- 19.60
4	БНХАУ-ын юань	CNY	-	0.06	3.54
5	БНСУ-ын вон	KRW	-	0.19	- 0.12
6	ОХУ-ын рубль	RUB	-	1.67	- 1.27
7	Японы иен	JPY	-	-0.46	- 0.75

Дээрх хүснэгтээс үзэхэд 2011 оны 3 дугаар улиралд Евро 19.6 төгрөг, БНСУ-ын вон 0.12 төгрөг, Оросын рубль 0.67 төгрөг, Японы иен 0.59 төгрөгөөр тус тус буурч, Хятадын юань 3.54 төгрөг, Английн фунт 70.19 төгрөг, АНУ-ын ам.доллар 28.50 төгрөгөөр тус тус өсчээ. Үүнээс үндэслэн нийт гадаад валют тус бүрийн хоорондын ханшийн зөрүү харьцангуй тогтуун байсан төдийгүй огцом хэлбэлзэл /100 төгрөгөөс илүү/ гараагүй байна.

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд арилжаалагдаж буй нийт валютын /60,281,976.5₮+65,160,574.4₮/ 125,442,550.9 мянган төгрөг буюу /48,597.00+52,274.8/ 100,871.8 мянган ам.доллар нь нийт валютын 40.8 хувийг, /80,176,658.9₮+82,849,813.7₮/ 163,026,472.6 мянган төгрөг буюу 53.0 хувийг юань, /5,262,608.6₮ + 5,580,118.1₮/ 10,842,726.7 мянган төгрөг буюу 3.5 хувийг евро эзэлж байгаа бөгөөд үлдсэн хувийг бусад валют эзэлж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР